



МУХАУТ-ЫН 2021 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮНДСЭН ЧИГЛЭЛ

ЭРХЭМ ЗОРИЛГО

МҮХАҮТ нь бизнесийн таатай орчныг бүрдүүлэхэд нөлөөлөгч, өмгөөлөгч, бизнесийн хөгжилд чиглүүлэгч, холбогч, дэмжигч байна.

АЛСЫН ХАРАА

МҮХАҮТ нь бизнесийн амжилтын ТАЛБАР байж, дэлхийн зах зээлийн өрсөлдөөнд манлайлахад ХӨТӨЧ нь болно.

ҮНЭТ ЗҮЙЛС

- Чадварлаг, эвсэг хамт олон
- Нягт, үр дүнтэй хамтын ажиллагаа
- Үнэ цэнэтэй бүтээгдэхүүн, үйлчилгээ
- Ёс зүйт үйл ажиллагаа
- Манлайлал

МУХАУТ-ЫН СТРАТЕГИЙН ЗОРИЛТ

2020-2023



1. Ил тод манлайллыг ил тод стратегээр хэрэгжүүлэх зорилтын хүрээнд:

- 1.1 УИХ-ын Тамгын газар, ЗГХЭГ-тай байгуулсан хамтын ажиллагааны санамж бичгийн хүрээнд төр хувийн хэвшлийн хэлцэл, түншлэлийг хөгжүүлэх
- 1.2 Бизнесийн орчинг сайжруулах чиглэлээр яам, агентлаг, бизнесийн төлөөллийн байгууллага, мэргэжлийн холбоод, олон улсын байгууллагуудтай хамтын ажиллагааг хөгжүүлэх, хороод, зөвлөл, ажлын хэсэгт бизнес эрхлэгчдийн болон Танхимын оролцоог хангах
- 1.3 Эдийн засаг, бизнесийн орчинг сайжруулахад гарч буй аливаа хууль, тогтоол, бодлого шийдвэрүүдэд бизнес эрхлэгчдийн санал зөвлөмж, шүүмжлэлийг тусгуулах, энэ чиглэлээр хийсэн ажлын үр дүнг тооцож, эргэх холбоотой ажиллах

2. Бизнесийн орчны болон бодлогын шийдлийг тодорхойлох чадамжтай байх, Бодлогод нөлөөлдөг байх зорилтын хүрээнд:

- 2.1 Бизнесийн орчинд тулгарч буй асуудлыг шийдвэрлүүлэх
 - Монголын Эдийн засгийн форум зохион байгуулж, гарсан санал санаачлагыг холбогдох байгууллагуудтай хамтран хэрэгжүүлэх
 - Танхимын дэргэдэх зөвлөлүүдийн үйл ажиллагааг тогтвортой явуулах, идэвхжүүлэх
- 2.2 Төр хувийн хэвшлийн хэлэлцлийн суурийг бүрдүүлэх
 - Төр хувийн хэвшлийн хэлэлцлийн хороодыг 21 аймагт байгуулах
- 2.3 Бизнесийн холбогдолтой хуулийн төсөл боловсруулах, шинэчилсэн найруулга, нэмэлт өөрчлөлт оруулах үүрэг бүхий ажлын хэсгүүдэд ажиллах
 - Хөдөлмөрийн тухай хуулийн шинэчилсэн найруулга
 - Зөвшөөрлийн тухай хуулийн төсөл
 - Арилжааны тухай хуулийн төсөл
 - Согтууруулах ундааны эргэлтэд хяналт тавих, архидан согтуурахтай тэмцэх тухай хуулийн шинэчилсэн найруулга
 - Худалдааны тухай хуулийн төсөл
- 2.4 Танхимын хууль эрх зүйн шинэчлэлийг хийх
- 2.5 Бизнесийн орчны судалгаануудыг явуулах, дүн шинжилгээ хийх
 - Бизнесийн итгэлийн индекс-2020 судалгаа явуулах
 - 2020 оны ТОП-100 ААН эрэмбэлэх
 - Хүнд суртлын индекс судалгаа явуулах
 - PMI судалгаа явуулах
 - Монгол улсын 2022 оны нэгдсэн төсвийн төсөлд санал өгөх
 - Гол нэрийн түүхий эд, бүтээгдэхүүний зах зээлийн үнийн тойм бэлтгэн гаргах

3. ЖДҮ, экспортыг дэмжих зорилтын хүрээнд:

3.1 ЖДҮ дэмжих чиглэлээр түнш байгууллагуудтай хамтын ажиллагааны төсөл хэрэгжүүлэх болон бусад төсөл хөтөлбөрүүдтэй хамтран ажиллах. Үүнд:

- МҮХАҮТ, ГХАҮТХ-ны /Германы худалдаа аж үйлдвэрийн танхимуудын холбоо/ хамтын ажиллагааны хүрээнд “Нэмүү өртгийн сүлжээг өргөжүүлэх, бүтээгдэхүүнийг хөгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх” төслийг Архангай болон Увс аймгуудад
- ЕХ-ны санхүүжилтээр хэрэгжүүлж буй “Монгол улсын худалдааг дэмжих” /Трам/ төслийн Экспортыг дэмжих төсөл
- Органик Монгол хөтөлбөр
- АХБ-ны “Эмэгтэйчүүдийн эдийн засгийн чадавхийг дэмжих” төсөл
- ЖАЙКА байгууллагаас хэрэгжүүлж буй ЖДҮ эрхлэгчдэд зориулсан бизнесийн зөвлөх үйлчилгээг үзүүлэх
- ЖАЙКА, ХХААХҮЯ, ҮХГ-ын хамтран хэрэгжүүлж буй “ХАА-н нэмүү өртгийн сүлжээ мастер төлөвлөгөө боловсруулах” төсөл

3.2 ЖДҮ дэмжих, чадавхжуулах чиглэлээр төсөл боловсруулж олон улсын байгууллагуудад өргөдөл гаргах, санхүүжилт олж, хэрэгжүүлэх, Монгол Улсад хэрэгжиж буй донор байгууллагуудын төсөл хөтөлбөрүүдтэй хамтран ажиллах

3.3 Танхимын дэргэд ажиллаж буй кластеруудын үйл ажиллагааг дэмжих, хөгжүүлэх, экспортын боломж потенциал бүхий бүтээгдэхүүний кластер шинээр байгуулж, хөгжүүлэх

3.4 ӨМӨЗО-ны Улаанцав хотод байгуулагдах “Монголд үйлдвэрлэв” үзэсгэлэнгийн Танхим байгуулахад хамтран ажиллах

4. Олон нийтэд нөлөө бүхий байгууллага байж бизнес эрхлэгчдийн нэр хүндийг өргөх зорилтын хүрээнд:

4.1 Гишүүдийн тоог өсгөж, сэтгэл ханамжийг нэмэгдүүлэх

4.2 TradeMongolia.MN вэб сайтыг бүх гишүүдэд танилцуулах, бараа бүтээгдэхүүн ажил үйлчилгээг байршуулах, олон нийтэд түгээх

4.3 Гишүүд болон бизнес эрхлэгчдийн хэрэгцээ шаардлагад нийцсэн бүтээгдэхүүн үйлчилгээг хөгжүүлэх, хэрэгжүүлэх

4.4 Гишүүд бизнес эрхлэгчдэд хэрэгцээтэй гадаад, дотоод уулзалт, хэлэлцүүлэг, сургалтыг үр дүнтэй зохион байгуулах

4.5 Бизнес эрхлэгчдийг дэмжин урамшуулах төрөл бүрийн арга хэмжээг үр дүнтэй, шинэлэг хэлбэрээр зохион байгуулах

4.6 Худалдааны салбар үүсч хөгжсөний 100 жилийн ойд зориулсан арга хэмжээ зохион байгуулах

4.7 Гишүүн байгууллагуудын гадаад хамтын ажиллагааг өргөжүүлэхэд дэмжлэг үзүүлэх, хоёр талт болон олон талт уулзалтуудыг цахимаар болон танхимаар хийх.

4.8 Монгол-Хятад-Орос 3 улсын Танхимуудын нэгдсэн уулзалт зохион байгуулах

4.9 Олон улсын худалдааны танхим, Дэлхийн танхимуудын холбоо, Азийн худалдааг дэмжих форум, Ази номхон далайн орнуудын худалдаа аж

- үйлдвэрийн танхимуудын холбоо, Торгоны зам олон улсын худалдааны танхим зэрэг худалдааг дэмжих байгууллагуудтай хамтын ажиллагааг өргөжүүлэх
- 4.10 Монгол Улсаас гадаадад суугаа Дипломат төлөөлөгчийн газар, Өргөмжит консулууд болон Монгол Улсад суугаа Дипломат төлөөлөгчийн газруудтай хамтын ажиллагааг идэвхжүүлэх
- 4.11 Салбар Танхимуудын үйл ажиллагааг дэмжих, удирдлага зохицуулалтаар хангах
- 4.12 БНХАУ, Япон, Солонгос улсад зохион байгуулагдах үзэсгэлэн яармагт гишүүд, бизнес эрхлэгчдийг оролцуулах
- 4.12 Дэлхийн ЭКСПО Дубай 2021, Хөх хотын ЭКСПО-д бизнес эрхлэгчдийг үр дүнтэй оролцуулах
- 4.13 Дотоод үзэсгэлэн арга хэмжээ
- Жижиг дунд үйлдвэрийн бүтээгдэхүүн үйлчилгээ технологи 2021” олон улсын үзэсгэлэн яармаг
 - “Улаанбаатар Түншлэл 2021” Олон улсын үзэсгэлэн яармаг зохион байгуулах
- 4.14 Танхимын үндсэн үйлчилгээнүүдийг үзүүлэх
- Экспортын барааны гарал үүслийн гэрчилгээ
 - АРТА /Ази, номхон далайн худалдааны хэлэлцээрийн хүрээнд гарал үүслийн гэрчилгээ олгох/
 - ЕХ-ны REX буюу “Бүртгэгдсэн экспортлогчдын систем”-д аж ахуйн нэгжийг бүртгэх
 - Аж үйлдвэрийн өмчийн эрхийн хамгаалалтыг хийх
 - АТА карней формыг олгох
 - Давагдашгүй хүчин зүйлийн гэрчилгээ олгох
 - Органик бүтээгдэхүүн ба Ногоон буудал, Эко шошго олгох
 - Экспертизийн үйлчилгээ
- 4.15 Гишүүн байгууллага, аж ахуйн нэгжүүдийн захирлууд, удирдах албан тушаалтнуудад манлайллын сургалтын хөтөлбөрийг хэрэгжүүлэх, сургалт зохион байгуулах
- Harvard managementor
 - Harvard Senior Executive Leadership program
 - Business model transformation - Master class
- 4.16 Арбитрын хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг хэвийн явуулах, арбитрын хуралдааныг цахим хэлбэрээр хийх “Цахим арбитр” төсөл хэрэгжүүлэх, Арбитрын хэрэг хянан шийдвэрлэх дүрмийг шинэчлэн батлуулах

Танхимын хууль дүрмийн хэрэгжилтийг хангах, дотоод хамтын ажиллагааг сайжруулах ажлын хүрээнд:

1. ISO9001:2015 чанарын удирдлагын тогтолцооны баталгаажуулалтыг ханган ажиллах, баталгаажуулалтын аудит хийлгэх
2. Мэдээлэл үйлчилгээний нэгдсэн системийг шинэчлэх, хөгжүүлэх
3. Хүний нөөцийн бодлого, дүрэм, журмыг боловсронгуй болгох
4. Хүний нөөцийн мэдлэг ур чадварын шаардлагыг тодорхойлж, сургалтын хэрэгцээнд үндэслэн, хүний нөөцийн чадавхийг бэхжүүлэх
5. Танхимын маркетинг, сурталчилгааг сайжруулах, хэрэглэгч ба гишүүдийн сэтгэл ханамжийн судалгаанд үндэслэн үйл ажиллагааг тогтмол сайжруулах